

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/191/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
БҮРЭН ДУНД СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага.....	20
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tiv@audit.gov.mn

2022.02.25 № 1/100
танай _____ -ны № _____ -т

**ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН БҮРЭН
ДУНД СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Л.ХОСБАЯР ТАНАА**

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020326

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	40,808,657.96	91,203,080.93
33	АВЛАГА	79,781.03	38,567,604.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	38,217,413.00
335	Бусад авлага	79,781.03	350,191.00
3351	Байгууллагаас авах авлага	79,781.03	350,191.00
35	БАРАА МАТЕРИАЛ	40,728,876.93	52,635,476.93
351	Түүхий эд материал	5,511,400.00	5,511,400.00
35110	Тусгай зориулалттай материал	5,511,400.00	5,511,400.00
354	Хангамжийн материал	35,217,476.93	36,764,076.93
35420	Аж ахуйн материал	17,484,000.00	16,154,500.00
35460	Хүнсний материал	00.00	2,876,100.00
35470	Бусад хангамжийн материал	17,733,476.93	17,733,476.93
35600	Мал амьтад	00.00	10,360,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,984,850,750.51	4,588,203,455.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,984,850,750.51	4,588,203,455.13
392	Биет хөрөнгө	4,912,201,250.51	4,515,553,955.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,642,656,043.02	5,718,156,043.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	-985,834,211.10	-1,364,388,090.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,509,218.00	41,744,198.70
39204	Хуримтлагдсан элэгдэл	-33,509,218.00	-30,710,532.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	221,137,589.35	218,036,314.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	-112,651,475.63	-163,411,348.91
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	184,565,253.06	164,282,971.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	-75,447,793.22	-115,878,561.67
39214	Бусад үндсэн хөрөнгө	31,162,701.27	40,161,951.27
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19,756,081.85	-22,251,303.27
39217	Ном	26,369,225.61	29,812,312.46
393	Биет бус хөрөнгө	72,649,500.00	72,649,500.00
39301	Программ хангамж	1,212,500.00	1,212,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	-275,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	71,712,000.00	71,712,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,025,659,408.47	4,679,406,536.06
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,025,659,408.47	4,679,406,536.06
51	Засгийн газрын хувь оролцоо	5,025,659,408.47	4,679,406,536.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,291,187,505.12	1,291,187,505.12
51101	Өмч: - төрийн	1,291,187,505.12	1,291,187,505.12
512	Хуримтлагдсан үр дүн	3,174,260,424.08	2,828,007,551.67
51210	Өмнөх үеийн үр дүн	3,174,260,424.08	3,174,260,424.08
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-346,252,872.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	560,211,479.27	560,211,479.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,025,659,408.47	4,679,406,536.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,447,692,942.97	1,492,927,976.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,010,631,442.97	1,092,130,085.57
120	Нийтлэг татварын бус орлого	16,966,742.97	121,240,385.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,966,742.97	121,240,385.57
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,966,742.97	121,240,385.57
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	993,664,700.00	970,889,700.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	993,664,700.00	970,889,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	437,061,500.00	400,797,891.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	353,611,000.00	375,430,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	353,611,000.00	375,430,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	83,450,500.00	25,367,691.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	83,450,500.00	25,367,691.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,815,539,004.03	1,829,347,075.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,815,539,004.03	1,829,347,075.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,615,996,262.77	1,752,994,781.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	709,616,518.95	688,002,657.00
210101	Үндсэн цалин	458,093,494.41	476,513,905.00
210102	Нэмэгдэл	176,993,725.54	150,097,321.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,904,403.00	15,117,520.00
210104	Урамшуулал	57,624,896.00	46,273,911.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,066,924.76	98,249,654.93
210201	Тэтгэврийн даатгал	66,355,587.93	69,018,356.89
210202	Тэтгэмжийн даатгал	6,706,029.14	7,345,008.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,684,982.68	5,858,886.43
210204	Ажилгүйдлийн даатгал	901,383.20	1,456,418.52
210205	Эрүүл мэндийн даатгал	13,418,941.81	14,570,985.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	349,594,204.00	374,015,146.00
210301	Гэрэл, цахилгаан	11,406,089.00	14,875,446.00
210302	Түлш, халаалт	327,188,115.00	341,552,200.00
210303	Цэвэр, бохир ус	11,000,000.00	17,587,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,110,800.00	6,166,916.00
210401	Бичиг хэрэг	519,700.00	1,019,391.00
210402	Тээвэр, шатахуун	464,000.00	774,187.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	585,000.00	225,000.00
210404	Ном, хэвлэл	95,000.00	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	330,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,117,100.00	2,398,838.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,329,500.00
2105	Нормативт зардал	51,597,920.00	68,560,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	140,000.00	500,000.00

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 2021 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	49,793,920.00	63,562,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,664,000.00	4,497,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	356,000.00	446,000.00
210702	Дотоод албан томилолт	356,000.00	446,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,369,700.00	2,915,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,369,700.00	2,915,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	400,284,195.06	513,638,457.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	176,200.00	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,810,170.00	2,349,980.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	398,297,825.06	509,288,477.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	199,542,741.26	76,352,294.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,134,803.00	58,326,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,204,303.00	34,993,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,197,100.00	3,608,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,253,400.00	18,224,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,480,000.00	1,500,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	99,407,938.26	18,025,894.10
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,407,938.26	18,025,894.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-367,846,061.06</u>	<u>-336,419,099.10</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	16,900,591.99	9,833,773.31
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	16,900,591.99	1,985,174.59
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	7,848,598.72
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-16,900,591.99	-9,833,773.31
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-384,746,653.05</u>	<u>-346,252,872.41</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,291,187,505.12	560,211,479.27	3,559,007,077.13	5,410,406,061.52
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,291,187,505.12	560,211,479.27	3,559,007,077.13	5,410,406,061.52
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-384,746,653.05	-384,746,653.05
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,291,187,505.12	560,211,479.27	3,174,260,424.08	5,025,659,408.47
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,291,187,505.12	560,211,479.27	3,174,260,424.08	5,025,659,408.47
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,291,187,505.12	560,211,479.27	3,174,260,424.08	5,025,659,408.47
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-346,252,872.41	-346,252,872.41
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,291,187,505.12	560,211,479.27	2,828,007,551.67	4,679,406,536.06

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,430,726,200.00	1,371,687,591.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	993,664,700.00	970,889,700.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	993,664,700.00	970,889,700.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	993,664,700.00	970,889,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	437,061,500.00	400,797,891.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	83,450,500.00	25,367,691.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	83,450,500.00	25,367,691.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	353,611,000.00	375,430,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	353,611,000.00	375,430,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,415,751,400.00	1,360,093,021.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,415,751,400.00	1,360,093,021.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,216,208,798.74	1,283,740,726.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	709,616,516.95	726,220,070.00
210101	Үндсэн цалин	458,093,702.41	514,731,318.00
210102	Нэмэгдэл	176,963,515.54	150,097,321.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,904,403.00	15,117,520.00
210104	Урамшуулал	57,654,896.00	46,273,911.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,146,707.79	98,169,873.90
210201	Тэтгэврийн даатгал	66,435,368.96	68,938,575.86
210202	Тэтгэмжийн даатгал	6,579,564.14	7,345,008.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,280,909.68	5,858,886.43
210204	Ажилгүйдлийн даатгал	1,099,830.20	1,456,418.52
210205	Эрүүл мэндийн даатгал	12,751,034.81	14,570,985.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	349,594,204.00	374,365,337.00
210301	Гэрэл, цахилгаан	11,406,089.00	15,225,637.00
210302	Түлш, халаалт	327,188,115.00	341,552,200.00
210303	Цэвэр, бохир ус	11,000,000.00	17,587,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,877,900.00	4,837,416.00
210401	Бичиг хэрэг	525,700.00	1,019,391.00
210402	Тээвэр, шатахуун	464,000.00	774,187.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	585,000.00	225,000.00
210404	Ном, хэвлэл	95,000.00	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	330,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,878,200.00	2,398,838.00
2105	Нормативт зардал	50,267,400.00	71,436,550.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	140,000.00	500,000.00
210502	Хоол, хүнс	47,731,400.00	66,438,800.00

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 2021 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,396,000.00	4,497,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	356,000.00	446,000.00
210702	Дотоод албан томилолт	356,000.00	446,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,369,700.00	2,915,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,369,700.00	2,915,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,980,370.00	4,349,980.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	176,200.00	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,804,170.00	2,349,980.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	199,542,601.26	76,352,294.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,134,663.00	58,326,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,204,163.00	34,993,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,197,100.00	3,608,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,253,400.00	18,224,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,480,000.00	1,500,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	99,407,938.26	18,025,894.10
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,407,938.26	18,025,894.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,974,800.00	11,594,570.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,974,800.00	11,594,570.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,974,800.00	11,594,570.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,974,800.00	11,594,570.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,974,800.00	11,594,570.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-14,974,800.00	-11,594,570.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/төгрөгөөр/	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,346,319,900.00	1,328,294,005.90	18,025,894.1	98.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,346,319,900.00	1,328,294,005.90	18,025,894.1	98.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,306,902,800.00	1,291,800,405.90	15,102,394.1	98.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	735,282,000.00	726,220,070.00	9,061,930.0	98.8
210101	Үндсэн цалин	489,237,100.00	514,731,318.00	(25,494,218.0)	105.2
210102	Нэмэгдэл	166,543,900.00	150,097,321.00	16,446,579.0	90.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,760,000.00	15,117,520.00	8,642,480.0	63.6
210104	Урамшуулал	55,741,000.00	46,273,911.00	9,467,089.0	83.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,263,000.00	98,169,873.90	1,093,126.1	98.9
210201	Тэтгэврийн даатгал	69,851,700.00	68,938,575.86	913,124.1	98.7
210202	Тэтгэмжийн даатгал	7,352,800.00	7,345,008.05	7,792.0	99.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,882,200.00	5,858,886.43	23,313.6	99.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,470,500.00	1,456,418.52	14,081.5	99.0
210205	Эрүүл мэндийн даатгал	14,705,800.00	14,570,985.04	134,815.0	99.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	374,430,200.00	374,365,337.00	64,863.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	15,404,500.00	15,225,637.00	178,863.0	98.8
210302	Түлш, халаалт	349,105,700.00	341,552,200.00	7,553,500.0	97.8
210303	Цэвэр, бохир ус	9,920,000.00	17,587,500.00	(7,667,500.0)	177.3
2104	Хангамж, бараа материалын зардал	5,335,000.00	5,331,325.00	3,675.0	99.9
210401	Бичиг хэрэг	700,000.00	700,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	774,187.00	(274,187.0)	154.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.00	225,000.00	275,000.0	45.0
210404	Ном, хэвлэл	335,000.00	333,300.00	1,700.0	99.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	2,998,838.00	1,162.0	100.0
2105	Нормативт зардал	76,314,600.00	71,436,550.00	4,878,050.0	93.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	500,000.00	-	100.0
210502	Хоол, хүнс	71,314,600.00	66,438,800.00	4,875,800.0	93.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,500,000.00	4,497,750.00	2,250.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	446,000.00	446,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	446,000.00	446,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,000,000.00	8,999,250.00	750.0	100.0

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,000,000.00	8,999,250.00	750.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5832000.00	5832000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,700,000.00	1,700,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,132,000.00	4,132,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39417100.00	36493600.00	2,923,500.0	92.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,417,100.00	36,493,600.00	2,923,500.0	92.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,917,100.00	34,993,600.00	2,923,500.0	92.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,346,319,900.00	1,346,319,900.00	-	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	970,889,700.00	970,889,700.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	970,889,700.00	970,889,700.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	375,430,200.00	375,430,200.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	375,430,200.00	375,430,200.00	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	60.00	60.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	36.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	23.00	23.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,367,691.00	25,367,691.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,367,691.00	25,367,691.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,534,891.00	3,534,891.00
2104	Хангамж, бараа материалын зардал	319,391.00	319,391.00
210401	Бичиг хэрэг	319,391.00	319,391.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,915,500.00	2,915,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,915,500.00	2,915,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	300,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,832,800.00	21,832,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,832,800.00	21,832,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,608,800.00	3,608,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,224,000.00	18,224,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25,367,691.00	25,367,691.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,367,691.00	25,367,691.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,367,691.00	25,367,691.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хөрөнгө бараа материалыг зөв ангилан бүртгэж, хөрөнгийн шамшигдал үүсгэхгүй байх, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал, Э.Батчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 09/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль нь сурагчдыг сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хүүхэд бүрийн хүмүүжил, хөгжил, төлөвшил, сурлагын чанарт ахиц гаргахыг зорилгоо болгон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, Захирлын 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн Захирлын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/25 дугаар тушаалаар дотоод хяналт шалгалтын нэгжийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Дотоод хяналт шалгалтын нэгж нь 2021 онд үйл

ажиллагааны төлөвлөгөөг батлан, 8 чиглэлээр дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж, жилийн эцсээр үр дүнг тайлагнасан байна.

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө, Төв аймгийн Засаг дарга бөгөөд дотоод аудитын хорооны даргын баталсан 33/31 тоот удирдамжийн дагуу 2019, 2020 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 1,346,319.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 20,194.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 15,146.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 1,346,319.9 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 25,367.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 1,360,093.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 75,500.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 30,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 13,237.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,130.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 3,443.1 мянган төгрөгийн ном, 8,999.3 мянган төгрөгийг бусад хөрөнгө, нийт 133,109.4 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 99,889.4 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 2,420.0 мянган төгрөгийн, балансаас баланст шилжүүлэн авсан 30,800.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 16,580.0 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 113,714.6 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 120,016.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 38,567.6 авлагатай, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Энэ нь дотоод хяналт шалгалтын үр дүнд ажиллагсадтай холбоотой үүссэн авлага байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд төгрөгийн үлдэгдэлгүй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 52,635.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 4,588,203.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	79.78	38,567.60	38,487.82
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	40,728.87	52,635.47	11,906.60
Үндсэн хөрөнгө	4,984,850.75	4,588,203.46	(396,647.29)
Нийт хөрөнгө	5,025,659.40	4,679,406.53	(346,252.87)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,025,659.40	4,679,406.53	(346,252.87)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,025,659.40	4,679,406.53	(346,252.87)

Бараа материалын дансны үлдэгдэл 52,635.5 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 11,906.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,588,203.5 мянган төгрөг болж 396,647.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардал өссөн, 60,315.6 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас тус тус шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,679,406.5 мянган төгрөг болж 346,252.9 мянган төгрөгөөр буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 1,346,319.9 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 1,306,902.8 мянган төгрөг, татаас ба урсгал шилжүүлгийн зардалд 39,417.1 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,306,902.8 мянган төгрөгийн урсгал зардал, 39,417.1 мянган төгрөгийн татаас ба урсгал шилжүүлгийн зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 1,346,319.9 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 1,328,294.0 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 18,025.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,328,294.0 мянган төгрөг буюу 98.7 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 25,367.7 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний зардалд 3,534.9 мянган төгрөгийг, урсгал шилжүүлэгт 21,832.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд үндсэн хөрөнгө дансанд 75,500.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 30,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 13,237.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,130.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 3,443.1 мянган төгрөгийн ном, 8,999.3 мянган төгрөгийг бусад хөрөнгө, нийт 133,109.4 мянган төгрөгийн хөрөнгийн орлого нэмэгдсэн.

Балансаас баланст шилжүүлэн авсан 30,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл нь Эрдэнэ сумын Хүн эмнэлэгт ашиглагдаж байсан УАЗ пургон автомашин байна.

Бараа материалын дансны 52,635.5 мянган төгрөгийн үлдэгдэл нь 16,154.5 мянган төгрөгийн аж ахуйн материал, 2,876.1 мянган төгрөгийн хүнсний материал, 17,733.5 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 10,360.0 мянган төгрөгийн үнэ бүхий мал амьтад байна.

3.8 Аудитын гол асуудал

Байгууллагын дотоод хяналтын баг нь Захирлын баталсан 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн "Төв аймгийн Эрдэнэ сумын ЕБС-ийн багш, ажилчдын амралтын мөнгөний олголтод гарсан зөрчлийг илрүүлэх" хяналт шалгалтын удирдамжийн дагуу амралтын мөнгө илүү бодогдсон шалтгааныг илрүүлэх зорилгоор хийсэн хяналт шалгалтыг гүйцэтгэж, хяналт шалгалтын үр дүнд 60 албан хаагчийн амралтын мөнгийг олгохдоо нийт 38,217.4 мянган төгрөгийн илүү олгосон зөрчил илэрсэн байна. Дээрх 38,217.4 мянган төгрөгийн зөрчлийг жилийн эцсийн санхүүгийн тайланд ажиллагсадтай холбоотой авлагаар бүртгэн тайлагнасан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс 144 мэдээллийг хугацаандаа, 2 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 88.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 2 албан шаардлага, 1,447.1 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гараагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 2021 санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 47,730.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8,376.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 38,767.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 587.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 8,376.1 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн дансанд 6 нэр төрлийн 8,376.1 мянган төгрөгийн хасах үлдэгдэлтэй хөрөнгө бүртгэлтэй байгаа нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, УСНББОУС 17-той тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 38,767.4 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд 35 албан хаагчдад нийт 13,200.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгосноос 1 албан хаагчаас 250.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалинг цалингаас суутгаагүй, дээрх албан хаагчтай холбоотой авлагыг санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй, тайлагнаагүй нь: Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүрэн аккурэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн илүү олгосон урьдчилгаа цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Захирлын 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн Б/46 дугаар тушаалаар Төрийн одон медаль, салбарын шагналаар шагнагдсан 3 албан хаагчид нийт 300.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 1.7-д “Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн илүү мөнгөн урамшууллыг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Байгууллагын дотоод хяналтын баг нь Захирлын баталсан 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн “Төв аймгийн Эрдэнэ сумын ЕБС-ийн багш, ажилчдын амралтын мөнгөний олголтод гарсан зөрчлийг илрүүлэх” хяналт шалгалтын удирдамжийн дагуу амралтын мөнгө илүү бодогдсон шалтгааныг илрүүлэх зорилгоор хийсэн хяналт шалгалтын үр дүнд 38,217.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлж ажилласадтай холбоотой авлага үүсгэж санхүүгийн тайланд тусгасан нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”

гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн илүү бодогдсон цалинг холбогдох албан хаагчдаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 2 нэр төрлийн 587.0 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материал бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 дугаар тогтоол, УСНББОУС 12-той тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн биет бус хөрөнгийг цаашид ашиглагдах боломжгүй бол холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 144 мэдээллийг хугацаандаа, 2 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль	6	47,730.5	1	8,376.1	3	38,767.4	-	-	2	587.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn